

МУБИС-ийн эрхэм зорилгоос ...

*Хүүхэд бүрийг хөгжүүлэх чадамжтай багш, боловсролын салбарын мэргэжилтэн бэлтгэх ...*

# ДҮРСЛЭХ УРЛАГ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ

## ЭЛСЭЛТИЙН ТАНИЛЦУУЛГА

77776226-2008
80207561

МУБИС-ИЙН ЭЛСЭЛТИЙН

http://burtgel.msue.edu.mn

Монголын ирээдүйн авьяастныг хөгжүүлэх, уран бүтээлч багш, зохион бүтээгч, дизайнер болох өргөн боломжтой.



77776226-2008
80207561

## СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР СОНГОЛТ:

| Хөтөлбөр | | Тайлбар |
|---|---|---|
| Давхар мэргэжлийн хөтөлбөр: | 3.3+ | голчтой оюутан III улирлын төгсгөлд суралцаж буй чиглэлээс өөр чиглэлээр хоёр дахь мэргэжил эзэмших боломжтой. |
| Хавсарга мэргэжлийн хөтөлбөр: | 2.7+ | голчтой оюутан IV улирлын төгсгөлд үндсэн чиглэлийнхээ мэргэжлийн кредитийг нэмж судлан хос мэргэжил эзэмших боломжтой. |
| Хөрвөх хөтөлбөр: | 1+1 | Багш болон мэргэжлийн чиглэлээр бакалаврын зэрэгтэй бол хоёр дахь мэргэжил эзэмших боломжтой. /Өмнөх дипломын кредит дүйцүүлэлт 90 кр-ээс ихгүй байх/. |
| Магистрын хөтөлбөр: | 3.5+1 | бакалаврт суралцах хугацаандаа магистрт суралцах боломжтой. |
| Докторын хөтөлбөр: | VII | улирлын төгсгөлд элсэн суралцах боломжтой. |

## УРАМШУУЛАЛ, ТЭТГЭЛЭГ:

**Монгол Улсын Засгийн газрын тэтгэлэг**
- 100% тэтгэлэг — 751+ оноотой элсэгч 4 жил
- 70% тэтгэлэг — 650-750 оноотой элсэгч 4 жил
- 500км+ — орон нутагтай суралцагчийн замын зардал
- Боловсролын зээлийн сангийн буцалтгүй тусламж
- Тэтгэлэгтэй багшлах дадлага
- Оюутны хөгжлийн зээл

**МУБИС-ийн тэтгэлэг**
- Захирлын нэрэмжит тэтгэлэг
- Кредитийн тэтгэлэг
- Өндөр оноотой элсэгчийн тэтгэлэг
- Өндөр оноотой эрэгтэй элсэгчийн тэтгэлэг

**Бусад тэтгэлэг**
- Төрийн болон төрийн бус байгууллагуудын бусад тэтгэлэг

МУБИС-ийн төв байрны хойно, Дүрслэх Урлаг Технологийн Сургууль, Хичээлийн-VII байр



77776226-2008
80207561

БОЛЗОЛ → Ур чадвар /Хар зураг, зохиомж/ · ЕШ-ийн 2 хичээл → 480+ ОНООТОЙ БАЙХ

## БАГШ МЭРГЭЖЛИЙН ХӨТӨЛБӨР

**Дүрслэх урлагийн багш:** Урлагийн гоо зүйн мэдрэмжтэй, дүрслэх урлагийн онол түүхийн мэдлэгтэй, Дүрслэх урлагийн бүхий л төрлийг орчин үеийн технологи, цахим сургалтын арга зүй ашиглан хэрэгжүүлэх чадамжтай багш, музей галерей зэрэг байгууллагад урлаг судлаач, уран бүтээлчээр ажиллах боломжтой хөрвөх мэргэжилтэн болж бэлтгэгдэнэ.

**Дизайн технологийн багш:** Шинэлэг сэтгэлгээтэй, дизайн загварчлал, зохион бүтээлт, техникийн онолын мэдлэгтэй, компьютерийн CAD, CAM, ухаалаг удирдлагын программчлалд суралцсан, уламжлалт ба дэвшилтэт технологийг хослуулан хэрэгжүүлэх чадвартай, дизайн технологийн сургалтын арга зүйн болон STEAM ур чадвар, хандлагатай, бүтээлчээр ажиллах, хөрвөн хөгжихүйц мэргэжилтэн болж бэлтгэгдэнэ.

**Дизайн зурагзүйн багш:** Чөлөөт сэтгэлгээтэй, Зурагзүйн болон дизайн, урлагийн боловсролын онолын мэдлэгтэй, орчин үеийн зургийн программууд (AutoCAD, 2dMAX, Illustrator, CorelDRAW, Vizo) ашиглан уран сайхны боловсруулалт, зохион бүтээлт хийн бие даан хөгжин, суралцах чадвартай мэргэжилтэн болж бэлтгэгдэнэ.

ЕБС, МСҮТ, Коллеж, Их дээд сургуульд багшлах,

галерей музейд урлаг судлаач, уран бүтээлч,

студид дизайнер, зохион бүтээгч технологичоор ажиллана.

## БАГШ БУС МЭРГЭЖЛИЙН ХӨТӨЛБӨР

**Компьютер график дизайн:** Чөлөөт, бүтээлч сэтгэлгээтэй, график, хэвлэл чимэглэлийн дизайн, компьютер загварчлалын үндсэн мэдлэг, орчин үеийн цахим технологи, арга хэрэгслийг цаг үеийн чиг хандлагад нийцүүлэн дизайн шийдлийг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх, бие даан хөгжих, хамтран ажиллах чадвартай, эх түүх, соёл, ёс заншил, уламжлалыг хадгалах, хамгаалах үзэл, уран бүтээлч хандлага төлөвшсөн мэргэжилтэн болж бэлтгэгдэнэ.

**Мульт медиа дизайн:** Чөлөөт, бүтээлч сэтгэлгээтэй, график, мультимедиа дизайн, видео, хөдөлгөөнт график, 2 болон 3 хэмжээст компьютер загварчлалын мэдлэг эзэмшсэн, орчин үеийн цахим, дижитал технологи, арга хэрэгсэл, эх сурвалжуудыг цаг үеийн чиг хандлагад нийцүүлэн дизайны цогц үйл ажиллагаанд хэрэглэх, бие даан хөгжих, хамтран ажиллах чадвартай, уран бүтээлч хандлага төлөвшсөн мэргэжилтэн болж бэлтгэгдэнэ.

**Хувцасны дизайн:** Хувцасны түүх, соёл, үндэсний хувцасны уламжлал, шинэчлэл, ёс заншил, хувцасны дизайны орчин үеийн мэдлэг эзэмшсэн; хувцасны зохиомж, дизайн шийдэл хийх, хувцасны оёдлын болон машин сүлжмэл, үслэг эдлэлийн технологи, арга зүйд суралцсан; хувцасны эсгүүрийн программ, мэргэжлийн зургийн программуудыг ашиглан зураг төсөл боловсруулж загварчлах, эсгэх, оёх, хувцасны загвар, маркетингийн төсөл боловсруулах чадвартай үндэсний брэнд хөгжүүлэгч мэргэжилтэн болж бэлтгэгдэнэ.

ТВ, студид аниматор,видео графикч, дизайнер, зураач, албан байгууллага, хэвлэл рекламны студид UI, UX дизайнер флатформ хөгжүүлэгч визуал дизайнер,

Их дээд сургууль, МСҮТ, сургалтын байгууллагад багшлах чадамжтай дизайнер, хувцасны зураач уран бүтээлчээр ажиллана.




МУБИС-ИЙН ЭЛСЭЛТИЙН

http://burtgel.msue.edu.mn

# ХӨТӨЛБӨРҮҮДИЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ОН

| № | Хөтөлбөр | Он |
|---|---|---|
| 1 | Дүрслэх урлагийн БАГШ ХӨТӨЛБӨР | 1958, 2006, 2021 |
| 2 | Дизайн технологийн БАГШ ХӨТӨЛБӨР | 1958, 2012, 2021 |
| 3 | Дизайн зургийн БАГШ ХӨТӨЛБӨР | 1998, 2021 |
| 4 | Компьютер график ДИЗАЙНЫ ХӨТӨЛБӨР | 2004, 2021 |
| 5 | Хувцас ДИЗАЙНЫ ХӨТӨЛБӨР | 2006, 2021 |
| 6 | Мультимедиа ДИЗАЙНЫ ХӨТӨЛБӨР | 2018, 2021 |

## Хамтын ажиллагааны хүрээнд бакалаврын 2+2 хөтөлбөр хэрэгжүүлдэг.

**ГАДААД ХАРИЛЦАА**

- ОХУ
- Япон
- БНХАУ
- БНСУ
- Польш

## Дүрслэх урлаг технологийн сургуулийн багшлах бүрэлдэхүүн

**37 НИЙТ БАГШ**

- 1 Шинжлэх ухааны доктор
- 2 Профессор
- 4 Дэд профессор
- 11 Доктор
- 9 Артист
- 8 Дизайнер

## Хөтөлбөрт нийцүүлэн сургалтын орчинд хийсэн шинэчлэл.

**СУРГАЛТЫН ОРЧИН**

- 4 Компьютерийн иж бүрэн лаборатори
- 18 Мэргэжлийн урлан
- 4 Цахим лекцийн танхим
- 2 Номын сан, инновацийн төв
- 2 Оюутны тохилог дотуур байр